

ЦЭРЭГ ТЕХНИКИЙН БОДЛОГО

Я.Ариунболд

*Дотоод хэргийн их сургуулийн
Удирдлагын академийн хилийн
албаны стратегийн тэнхимийн
профессор, докторант, хурандаа*

Товч агуулга: Төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудад үндэсний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай цэрэг техникийн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны тасалдлыг арилгах зорилгоор цэрэг иргэний харилцаан дээр тулгуурласан цэрэг аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагаа болон гадаад улсуудтай хийх цэрэг техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэн тэлж, улмаар цэрэг техникийн салбарт экспорт, импортын зохистой харьцааг хангах боломжийг бүрдүүлэх.

Түлхүүр үгс: Цэргийн техник, зэвсэг, галт хэрэгсэл, галт хэрэглэл, материал хэрэгсэл, техник хэрэгсэл, хилийн цэргийн хангалт.

Удиртгал

Аливаа тусгаар улсын хөгжил нь тухайн улс орны үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурласан

хөгжлийн бодлого, түүний хэрэгжилтээр тодорхойлогддог.

Хөгжлийн бодлого гэж улс, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг¹ хэлдэг.

Төрийн бодлого нь гадаад, дотоод нөхцөлөөс хамаарах бөгөөд бүрэлдэхүүнд нь цэргийн бодлого багтана.

Цэргийн бодлого гэж аливаа улсын улс төрийн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд цэргийн байгуулалтыг хөгжүүлэх, зэвсэгт тэмцлийн хэрэгслийг бэлтгэх, хэрэглэхтэй шууд холбоотой бодлогын бүрэлдэхүүн хэсэг юм.

Үндсэн хэсэг

Цэрэг, техникийн бодлого

Цэргийн бодлогод зэвсэгт хүчний (төрийн цэргийн байгууллагуудын Ж.Ж) бүтэц, зохион байгуулалтыг хөгжүүлж боловсронгуй болгох, зэвсэг техникийн хөгжил, хэтийн төлөвийг тодорхойлох, улсын дайчилгааны бололцоог тооцох, цэргийн боловсрол эзэмшсэн

¹ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль. 4 дүгээр зүйл.

Хуулийн нэр томьёоны тодорхойлолт. УБ.2020

иргэдийн нөөцийг бэлтгэх, зайлшгүй шаардлагатай үед зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах зэрэг асуудал чухал байр суурь эзэлдэг¹.

Цэргийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг нь цэрэг техникийн бодлого юм. Цэрэг-техникийн бодлого нь улс орны үндэсний аюулгүй байдлын цэрэг-техникийн хангалтыг хангах зорилгоор төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын хэрэгжүүлж байгаа бодит үйл ажиллагаа ба зарчмын үзэл бодлын цогц². Цэрэг-техникийн бодлогын гурван бүрэлдэхүүн хэсэг (зэвсгийн систем, батлан хамгаалах аж үйлдвэрийн цогцолбор, цэрэг-техникийн хамтын ажиллагаа)-ийг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө нь үндсэн зорилго, зорилтын хувьд нэлээд зөв уялдаж байх ёстойг тэмдэглэх нь зүйтэй³.

ОХУ, АНУ, Франц, Герман, Япон зэрэг хөгжингүй орнуудад цэргийн номлолынхоо хүрээнд гаргасан цэрэг техникийн бодлого, түүнийг дагасан цэргийн техникийн болон төрийн зэвсэглэлийн хөтөлбөр зэрэг 6-30 жилийн хугацаатай, 2-5 жил тутамд тодотгодог дунд, урт хугацааны баримт бичгүүд, 1-3

жилийн хугацаатай төлөвлөгөөнүүдийг батлуулж, түүний хэрэгжилтийг хангах замаар шийдвэрлэж байна.

Энэхүү бодлогод тодорхой зорилго, зорилтуудыг тусгах бөгөөд цэрэг, зэвсгийн шинэчлэлийг хийх хугацаанд хүрэх зорилтот хувь, түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх төрлийн хөрөнгө оруулалтыг тогтвортой байлгахаар заадаг.

Бодлогын хүрээнд гарсан хөтөлбөрүүд нь судалгаа шинжилгээ, зохион бүтээх технологи, туршилт, үйлдвэрлэл, худалдан авалт, засвар, ашиглалт, устгал, үйлчилгээ, хүний нөөц, түүний сургалт бэлтгэл зэрэг цогц үйл ажиллагааны нэгдлийг хангадаг байна.

Дэлхийн цэргийн аж үйлдвэрийн хөгжил нөөцийн хомсдол, эрэлт хэрэгцээний хязгаарлалттай тулгарч байна. Цэргийн аж үйлдвэрийн хөгжлийн загварыг өөрчилж, цэргийн технологийн шинэчлэл, өндөр технологийн аж үйлдвэржилтийг дэмжин, цэрэг-иргэний интеграцлал явагдаж байна.

Ирээдүйд цэргийн аж үйлдвэрийн өөрчлөлт нь дэлхийд хурдацтай хөгжлийг авчирна гэж үзэх хэсэг бий.

¹ Цэргийн нэр томъёоны тайлбар толь. 2014. УБ. 349 дэх тал

² Рогозин. Д. Война и мир. Москва. 2014

³ Поповкин В.А. Первый заместитель Министра обороны РФ. Особенности военно-технической политики

Российской Федерации в современных условиях.

<http://federalbook.ru/files/OPK/Soderjanie/OPK-7/III/Popovkin.pdf>

Хүснэгт 1. Дэлхийн
тэргүүлэгч улс орнуудын
зэвсэглэл ба цэргийн

техникийг хөгжүүлэх
хөтөлбөрүүдийн харьцуулалт

ЗЭВСЭГЛЭЛ БА ЦЭРГИЙН ТЕХНИКИЙГ ХӨГЖҮҮЛЭХ УРТ БА ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨРҮҮД				
Улс	Нэршил	Үйлчлэх хугацаа	Тодотгох журам	Хамрагдаж буй зэвсэглэл, цэргийн техникийн амьдралын үе шатууд
Орос	Төрийн зэвсэглэлийн хөтөлбөр	10 жил	5 жилд 1 удаа	Шинжлэх ухаан-судалгааны болон зохион бүтээлт туршилтын ажлууд, худалдан авалт болон үйлчилгээ хийх
АНУ	Батлан хамгаалах яамны хэтийн хөтөлбөр	6 жил	2 жилд 1 удаа	Шинжлэх ухаан-судалгааны болон зохион бүтээлт туршилтын ажлууд, үйлдвэрлэл, дэлгэлт, ашиглалт болон устгалт
Франц	Хэтийн төлөвлөгөө "PP 30"	30 жил	Жил бүр	Үзэл баримтлал
	Зэвсэгт хүчний байгуулалтын болон техникийн хангамжийн хөтөлбөр	6 жил	2-3 жилд 1 удаа	Үйлдвэрлэлийн боловсруулалт, туршилт, үйлдвэрлэл, оперативын бэлэн байдалд байлгах, зэвсэглэлээс авах
Герман	Бундесверийн байгуулалтын төлөвлөгөө	15 жил	Жил бүр	Шинжлэх ухаан-судалгааны болон зохион бүтээлт туршилтын ажлууд, үйлдвэрлэл

Япон	Үндэсний батлан хамгаалах хөтөлбөрийн үндсэн чиглэлүүд	20 жил	1. Зэвсэгт хүчний байгуулалтын 4 жилийн, дунд хугацааны төлөвлөгөөн ил хүрээнд 2. Жил бүр	Худалдан авалт, засвар, ашиглалт, устгалт
Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ойрын хугацааны төлөвлөгөөнүүд				
Улс	Нэршил		Үйлчлэх хугацаа	
Орос	Төрийн батлан хамгаалалтын захиалга		3 жил	
АНУ	Хөтөлбөр "R-1" (шинжлэх ухаан-судалгааны болон зохион бүтээлт туршилтын ажлууд) ба "P-1" (зэвсэглэл, цэргийн техникийн үйлдвэрлэл) жилийн төсвийн хүрээнд		1 жил	
Франц	Жилийн, цэргийн төсвийн хүрээний Батлан хамгаалах яамны санхүүгийн чиг үүргүүдэд харгалзах батлан хамгаалалтын захиалга		1 жил	
Герман	Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх хөтөлбөр		1 жил	
Япон	Өөрийгөө хамгаалах хүчнийг боловсронгуй болгох төлөвлөгөө		1 жил	

Дэлхийн улс орнуудын цэрэг техникийн бодлого

Дэлхийн цэрэг техникийн бодлогын томоохон өөрчлөлтийг анх 1993 онд АНУ нь цэргийн үйлдвэрлэлийн технологийн шилжилт хийхийн тулд цэрэг техникийн бодлогын шилжилтийг хэрэгжүүлэх чиглүүлэх, зохицуулах зорилгоор "Үндэсний батлан хамгаалахын технологийн шилжилтийн хороо" гэж салбар дундын агентлаг байгуулж, шинэчлэл хийж¹ улмаар 1996 онд

АНУ-ын Шинжлэх ухаан, технологийн үндэсний комисс "Технологи ба үндэсний аюулгүй байдал" хэмээх бодлогын чухал баримт бичигт анх удаа цэргийн болон иргэний үйлдвэрлэлийн баазыг нэгтгэх асуудлыг хөндөж, иргэний салбарт шинээр гарч ирж буй өндөр технологийг эзэмших зорилгоор 30 мянга гаруй хувийн өндөр технологийн аж ахуйн нэгжийг цэрэг, иргэний хамтын ажиллагааны жагсаалтад оруулж, "Иргэний технологийг ашиглах,

1

https://www.sohu.com/a/465011225_63579

2


дэмжих санаачилга"-д нэгтгэжээ. Үүний дараа дэлхийн олон оронд энэхүү шинэчлэлт хийгдсэн байдаг.

Өдгөө дэлхийн цэрэг, улс төрийн цагийн байдал жил бүр ээдрээ төвөгтэй болж, хүйтэн дайнаас хойш буюу 1985 оноос сулраад байсан цэрэг зэвсэглэлээр хөөцөлдөх үйл явц дэлхий даяар

2006 оноос нэмэгдэж, сүүлийн жилүүдэд өсөлт үзүүлж эхлэв.

Дэлхийн улс орнуудын цэрэг техникийн салбарт хийсэн технологийн шинэчлэлүүд нь тэдгээрийн хооронд өрсөлдөөнийг үүсгэж эхэлсэн байна.

Зураг №1. Олон улсын зэвсэглэлээр хөөцөлдөх чиг хандлага (1981-

2020 он)¹


Жишээ нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2010.12.31-нд баталсан “Төрийн зэвсэглэлийн хөтөлбөр” нь 2011-2020 оны хооронд цэрэг зэвсгийн шинэчлэлийг 70 хувьд хүргэх зорилт тавьж, түүнийгээ хэрэгжүүлэхэд 19 тэрбум рубль зарцуулсан бол 2018 онд 2020-2027 хүртэл хэрэгжүүлэх дараагийн хөтөлбөрийг баталж, түүндээ 20 тэрбум рубль зарахаар тооцож, цэрэг зэвсгийн шинэчлэлийг 100 хувьд хүргэхээр тусгажээ.

Хөтөлбөрийн үр дүнд дэлхийд I байрт бичигдэх тавдугаар үеийн тив алгасагч

пуужингийн Сармат болон пуужингийн Рубеж цогцолборуудыг бүтээгээд байна. Ялангуяа сүүлийн 10 жилд дэлхийн улс орнуудад цэргийн номлол болон цэргийн стратеги, цэрэг техникийн бодлогууддаа өөрчлөлт оруулах үйл явц өрнөв. Энэ талбарт тэргүүлэгч гэгдэх АНУ, ОХУ, БНХАУ болон хөгжингүй болон хөгжиж буй улсуудад энэ үйл ажиллагаа эрчимтэй явагдаж, улмаар цэрэг зэвсгийн үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, хэрэглээгээ өндөрсгөж байна.

Зураг №2. Зэвсэг экспортлогч орнуудын зах зээлд эзлэх хувь (2016-2020 он)


¹ http://sipri.org/sites/default/files/2021-3/fs_2103.pdf



Хамгийн том зэвсгийн экспортлогчид нь АНУ, Орос, Франц, Герман, Хятад улс хэвээр байна. Зэвсгийн гол хэрэгцээг Алс Дорнодын бүс нутаг хангадаг бөгөөд Саудын Араб дэлхийн хамгийн том зэвсгийн импортлогч болжээ¹.

Энэ зах зээлд ажиглагдаж буй нэг онцлог нь цэрэг зэвсгийн

экспортод 2011-2015 оны дараагаас өөрчлөлт орж Азиас БНСУ, Европоос Израйл, Франц улсууд 2016-2020 оны хооронд цэрэг зэвсгийн худалдаанд идэвхтэй байр суурьтай оролцох болсныг олон улсын шинжээчид онцолж байна.



Зураг №3. Зэвсэг экспортлогч орнуудын зах зээлд эзлэх хувь (2016-2020 он)²

Үүнд нөлөөлж буй хүчин зүйл нь сүүлийн жилүүдэд болж

буй цэрэг дайны үйл ажиллагаанд орж буй өөрчлөлтүүд юм.

¹ [www.vesti.ru/Мировой рынок вооружений 2020: главные поставщики и покупатели увеличили активность](http://www.vesti.ru/Мировой_рынок_вооружений_2020:_главные_поставщики_и_покупатели_увеличили_активность)

² https://sipri.org/sites/default/2021-03/fs_2013_at_2020.pdf

Тухайлбал, 2020 онд Армени болон Азербайжан улсын хооронд хил орчмын газар нутгийн маргаантай байдлаас үүссэн зэвсэгт мөргөлдөөн нь эдгээр улсад зэвсгийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлсэн. Хоёр улс зэвсэглэл, тэр дундаа пуужингийн худалдан авалтаа нэмэгдүүлсэн. Армени улс 100 хувь Оросоос зэвсэг авдаг бол Азербайжан улс цэрэг зэвсгийн шинэчлэлт хийж, худалдан авалтын 60 хувийг Израйлаас, 31 хувийг Оросоос авсан. Үлдэх есөн хувийг бусад улс орноос авсан бөгөөд ялангуяа Турк улсаас авсан Байрактар ТБ2 нисгэгчгүй нисэх хэрэгсэл¹⁰ үр дүнтэй ашиглагдсан билээ.

АНУ нь цэрэг техникийн бодлогоо хэрэгжүүлэхдээ цэрэг-иргэний технологи шилжүүлэх бодлогыг чухалд авч үздэг. Үүнд:

1. Цэргийн салбарт иргэний дэвшилтэт технологиудыг шууд нэвтрүүлэх, төсөл хэрэгжүүлэх;

2. Иргэний болон цэргийн үйлдвэрлэлийг нэгтгэсэн “давхар хэрэглээний үйлдвэрлэл” төсөл боловсруулж, хэрэгжүүлэх

3. Иргэний салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйл явцад дэмжлэг үзүүлэх

4. Технологийн судалгаа, хөгжлийн төв эсвэл технологи сурталчлах төвөөр дамжуулан цэргийн болон иргэний давхар хэрэглээнд хүрэх, технологийн ололт амжилтыг хоёр талын

дамжуулалт эерэг харилцан үйлчлэлээр хангах явдал бөгөөд АНУ-ын сансрын агентлаг НАСА нь цэргийн өндөр технологийг иргэний салбарт өргөнөөр ашиглаж, сүүлийн арван жилд шинжлэх ухааны судалгаанд 25 тэр бум ам долларын орлого олжээ. Нийт дүнгээр өнгөрсөн хугацаанд батлан хамгаалахын зардлаас жилд 30 тэрбум ам доллар хэмнэж, хүний нөөцийн 20 гаруй хувийг цомхотгож чаджээ¹.

АНУ-д цэргийн аж үйлдвэрийн салбарт 100 гаруй корпорац үйл ажиллагаа явуулж, үндэсний батлан хамгаалахын судалгаа, үйлдвэрлэлийн санхүүжилтийн 70-75 орчим хувийг гаргаж, тэднээс шилдэг 25 нь үндэсний батлан хамгаалахын судалгаа, үйлдвэрлэлийн санхүүжилтийн 50 орчим хувийг эзэлж байна.

Монгол улсын хувьд цэрэг техникийн салбарт экспорт, импортын зохистой харьцааг хангах боломжтой.

Монгол Улсын цэрэг техникийн бодлого

Монгол Улс нийгмийн шинэ тогтолцоонд хөгжих зарчим, үзэл баримтлал, нэгдмэл бодлогоо тодорхойлон хэрэгжүүлэх чадваргүй байна. 1990 оноос хойш хөгжлийн талаар төрөөс уялдаа холбоо, тооцоогүй 490 шахам бодлогын баримт бичиг баталсан

¹

https://www.sohu.com/a/465011225_63579

²

боловч тэдгээр нь хангалттай хэрэгжээгүй¹ гэсэн дүгнэлтийг эрдэмтэд гаргажээ.

Улмаар Монгол Улсын Засгийн газраас Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурласан, “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийг батлуулж, ирэх 30 жилийн бодлогоо батлав. Мөн дэлхийн улс орнууд батлан хамгаалах номлол, бодлого үйл ажиллагаандаа өөрчлөлт оруулсан болон Монгол Улс хөгжлийн бодлогоо шинээр авч үзэж буйтай уялдуулан, 2020 оноос батлан хамгаалах салбар болон Хил хамгаалах байгууллага нь эрх зүйн орчны шинэчлэлүүдийг хийж, багц хуулиудыг үе шаттай батлуулсаар байна.

Монгол Улсын орчин цагийн цэргийн бодлого нь “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгээр Монгол Улсын Их хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталгаажсан байдаг.

Энэхүү баримт бичигт 1.1 Монгол Улсын батлан хамгаалах бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд улсын дотоод, гадаад аюулгүй байдлын орчин нь батлан хамгаалах зорилго, зарчим,

чиглэлийг тодорхойлох үндэс болно² гэж заасан бол “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого” нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг мөн³ гэж тус тус заажээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурласан, “Алсын хараа-2050”, “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”, “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангахад судлаачийн зүгээс Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэд “Цэрэг-техникийн бодлогын хороо” байгуулж, уг хороо “Монгол Улсын цэрэг техникийн бодлого” баримт бичгийг боловсруулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж байх саналыг дэвшүүлж буй юм.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд, түүний ажлын алба болон төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагын удирдлага нь хорооны гишүүн байж, харьяалах байгууллагуудад бодлогыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх орон тооны бус нэгжүүдтэй байна. Үгүй бол тухайн салбаруудын шинжлэх ухааны хүрээлэн нь

¹ Монгол улсын дунд хугацааны (2020-2025) тогтвортой хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл (Тайлан III) 70 дах тал

² Монгол улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоол. Монгол улсын батлан

хамгаалах бодлогын үндэс, Нэг нийтлэл үндэслэл УБ

³ Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. Нэг нийтлэл үндэслэл 1.1. УБ

салбар хорооны ажлыг хариуцах боломжтой юм. Учир нь цэрэг техникийн бодлогыг боловсруулахад салбарын санал гаргах, салбарт шинэ техник технологи, инновац нэвтрүүлэхэд тухайн салбарын шинжлэх ухааны байгууллагуудын эрдмийн зөвлөл, эрдэмтдийн оролцоотой хэлэлцэж, шийдвэрлэдэг байх нь олон улсын жишигт нийцэх юм.

Мөн бодлогод тухайн жилийн төсвөөс үл хамаарсан урт, дунд, богино хугацааны тасралтгүй хөрөнгө оруулалт хийгдэж, жил бүрийн төсвийн тодорхой хувьтай тэнцэхүйц тогтмол зардлыг нэг хувиас доошгүй төсвийн хуулиар шууд олгодог байх эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай.

Төрийн цэргийн болон тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд нь Хил хамгаалах байгууллагын хувьд хилийн цэргийн цэрэг техникийн үйл ажиллагаа явуулах бөгөөд энэхүү үйл ажиллагааг "Цэрэг техникийн бодлого"-ын хорооны салбар хороо хэрэгжүүлж болох юм.

Цэрэг техникийн бодлогын хороо нь дараах үйл ажиллагааг явуулж болно гэж үзэж байна. Үүнд:

- Цэргийн зэвсэг, техник, технологи, программ хангамж, тусгай хэрэгсэл бүтээх, турших, боловсруулах, засварлах, ашиглах чиглэлээр төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх;

- Засгийн газар хоорондын "Цэрэг техникийн хамтын

ажиллагааны хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангах;

- Гадаад улс, орнуудтай ялангуяа гуравдагч хөрш орнуудтай цэрэг зэвсгийн хамтын ажиллагааг өрнүүлэх, өргөжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

- Улсын болон төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын цэрэг техникийн холбогдолтой төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авах, төлөвлөх, хэрэгжүүлэх захиалгыг боловсруулах, техник, технологи, программ хангамжийг хүлээн авах, хуваарилах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох;

- Цэрэг техникийн үйл ажиллагаанд ашиглах техник, технологи, программ хангамжийн стандартчилал болон түүний судалгаа, зохион бүтээх, турших, технологийг нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагааг салбар хооронд зохицуулж, үйл ажиллагаанд шилдэг инновац нэвтрүүлэх өрсөлдөөнийг дэмжих;

- Төрийн цэргийн болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд шаардлагатай цэргийн техник, технологи, программ хангамж, инновацыг нэвтрүүлж, цэрэг иргэний технологи шилжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, үр ашиггүй зардал гаргуулахгүй зохицуулалт хийх;

- Цэрэг техникийн бодлогын хүрээнд нэвтрүүлсэн зэвсэглэл техникийг хүлээн авах, шилжүүлэх, зориулалтын дагуу ашиглаж буй байдалд хяналт тавих, тоолох, ашиглалтаас хасах, устгах;

- Цаашид цэрэг техникийн бодлогыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах.

Чиг үүргийн хувьд

"Монгол Улсын цэрэг техникийн бодлого"-ын өнөөгийн байдал, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх болон цаашдын чиг хандлагын урьдчилсан таамаглал боловсруулах;

Цэрэг техникийн ирээдүйн чиглэлийг тодорхойлж, төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудад чухал ач холбогдолтой зэвсэглэл, техник, технологи, программ хангамжийг хөгжүүлэх, инновацын дэвшилтэт технологиудыг нэвтрүүлэх талаар санал бэлтгэх, хэрэгжүүлэхэд оролцох;

Цэрэг техникийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн актуудыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

Цэргийн техник, технологи, программ хангамжуудыг бүтээх, хөгжүүлэх, турших, нэвтрүүлэх, засварлах чиглэлээр бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, олон улсын хамтын ажиллагааны хүрээнд цэрэг техникийн бие даасан төслүүдийг хэрэгжүүлж, хяналт тавих

Төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын саналыг үндэслэн шаардлагатай цэрэг техникийн бодлогын нэмэлт үйл ажиллагааг хэрэгжүүлж, тэдгээрийг арга зүй болон мэдээллээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

Цэрэг аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагааг чиглүүлэх, хяналт тавих;

Ирээдүйтэй зэвсэг, техник, программ хангамжийг бүтээх, боловсруулах, турших, нэвтрүүлэх чиглэлээр үндэсний компаниудын оролцоог нэмэгдүүлж, хүний нөөцийн тусгай бодлого хэрэгжүүлэх;

Тусгай зориулалтын хиймэл дагуулын систем, онгоц, нисдэг тэрэг, усан болон авто тээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, улсын болон төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангаж, үр ашигтай хамтран эзэмших боломжийг бий болгох;

Цэргийн удирдлагын автоматжуулалт, нисгэгчгүй нисэх хэрэгсэл, хиймэл оюун ухаан, роботын удирдлагын системийг бий болгох, хөгжүүлэх, шинэчлэх төслүүдийг дэмжих;

Цэрэг техникийн зориулалттай аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний стандартчилал, баталгаажуулалтын чиглэлээр

хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах;

Цэрэг техникийн инновацын шинэ бүтээл, оновчтой санал, судалгаа шинжилгээний ажлыг үнэлэх, арилжаалах, өмчлөх эрхийг хуваарилах, тэдгээрийг хэрэгжүүлэх гэрээний төслийг хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх;

Олон улс болон төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг зохицуулах, харилцан ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хамтарсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэг байж болох юм.

Энд нэг тодруулахад Монгол Улс цэрэг техникийн бодлогогүй байсан гэх өрөөсгөл ойлголт гарч болох бөгөөд ганц төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллага хоорондын харилцааг уясан нэгдмэл бодлого байхгүй байна гэдгийг онцолсон билээ. Өөрөөр хэлбэл манай улс өдгөө “Цэрэг техникийн бодлого” баримт бичгийг тусад нь гаргаагүй ч салбар бүр өөрийн бодлого үйл ажиллагаандаа цэрэг техникийн бодлогыг баримталж байдаг.

Тухайлбал, “манай зэвсэглэлд байгаа зэвсэг, байлдааны техникийн дийлэнх

загварууд хуучин ЗХУ-д 60-70-аад онд үйлдвэрлэсэн, сүүлийн жилүүдэд технологийн дагуу сэргээн сайжруулах засвар, техникийн үйлчилгээ хийгдээгүй хэдий ч ашиглалтын зохих нөөцтэй, технологийн чанар байдлын хувьд зориулалтаар нь ашиглах боломжтой, гэхдээ тэдгээрт сэргээн сайжруулах техникийн үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай байгаа зэвсэглэл техник юм. Зэвсэг, цэргийн техникийн хадгалалт, арчлан хамгаалалт, техникийн үзлэг, үйлчилгээг үндсээр нь сайжруулж, шууд зориулалтаар нь ашиглах боломжийг хадгалах нь манай цэрэг-техникийн бодлогын үндэс болдог¹” гэж дурдсаныг сануулъя.

Ирээдүй ба өнөөгийн байдал

Хил хамгаалах байгууллагад ирэх он жилүүдэд тулгамдаж болох асуудал буюу өнөөгийн байдлыг цухас тоймлон авч үзлээ. Үүнд:

“Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт Хил хамгаалах байгууллагын ирэх 30 жилийн үйл ажиллагааны зорилго, зорилтуудад техник, технологийн шинэчлэлтийг түлхүү хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Тухайлбал, тус баримт бичгийн долоодугаар бүлгийн амар тайван, аюулгүй нийгэм хэсэгт “Дархан хил” хөтөлбөр

¹ Ш.Паламдорж. Монголын цэргийн шинэчлэл - ардчилсан иргэний хяналт. Женев-Улаанбаатар. 2003. 40 дэх тал

дэвшүүлж үе шатуудад хуваасан байдаг.

Нэгдүгээр үе шат (2021-2030): Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх үе буюу улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлж, албаны бэлэн байдал дээшилсэн байна.

Хоёрдугаар үе шат (2031-2040): Мэргэшсэн хилчин, технологид суурилсан хил хамгаалах албыг бэхжүүлэх үе буюу улсын хилийг агаараас хянах системд шилжүүлж, хиймэл дагуулыг хил хамгаалалтад ашиглана. Улсын хил хамгаалалтад хиймэл оюун ухаан, хяналт шалгалтын технологийн шинэчлэлийг нэвтрүүлж, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх чадавх дээшилсэн байна.

Гуравдугаар үе шат (2041-2050): Хил хамгаалалтын чадавхыг бэхжүүлж, гадаадын ижил төстэй байгууллага, хөрш

орнуудын түвшинд хүргэх үе буюу цахим технологид суурилсан хил хамгаалалтыг бэхжүүлж, найдвартай, шуурхай байдлыг хангасан байна¹ гэж тус тус заажээ.

Гэвч энэхүү зорилт хэрэгжихгүй байх магадлал өндөр байна. Тухайлбал, Хил хамгаалах байгууллагын хувьд хилийн инженер техникийн байгууламж, зэвсэглэл, автомашин техникийн парк шинэчлэлт, мэдээлэл, холбооны техник хэрэгслийн шинэчлэл, сайжруулалт, засвар үйлчилгээний зардал, төсвийн хөрөнгө оруулалт нь шаардлагатай цаг хугацаанаасаа үргэлж хоцорч, улмаар тулгамдсан асуудал болон хувирч байдаг.

Өөрөөр хэлбэл өдөр тутмын үйл ажиллагаанд өдгөө ашиглагдаж буй техник технологийн урсгал засвар, үйлчилгээний зардлыг өнөөг хүртэл тогтвортой цаг хугацаанд нь шийдэхгүй байгаа нь цаашид 2020-2050 онд технологийн хил хамгаалалтад шилжиж олон өөрчлөлт хийсэн тохиолдолд удирдлагын автоматжуулалт, дохиолол хяналтын нэгдсэн систем, улсын хилийг агаараас хянах, хиймэл дагуулыг хил хамгаалалтад ашиглах, хиймэл оюун ухаан, бүхий хяналт шалгалтын технологийн

¹ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого.

шинэчлэлийг нэвтрүүлж, түүнийг дагасан орон тоо зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого явуулсны дараа санхүүжилтийн хүндрэл учрах эрсдэл байна. Энэ нь буцаад уламжлалт хамгаалалт руу шилжих ёстой гэсэн бодлого гарахад ч хүргэж мэдэх юм.

Энэхүү болгоомжлол, учирч болзошгүй эрсдэл нь хилчдийн үйл ажиллагаанаас гэхээс илүүтэй төсвийн хөрөнгө оруулалт төлөвлөсөн цаг хугацаандаа хийгдэхгүй, улмаар улсын эдийн засаг, түүний санхүүгийн хүндрэлээс шалтгаална гэж үзэж байна.

Тухайлбал, Засгийн газрын мөрийн хөтөлбөрөөс шууд хамааралтай буюу богино хугацааны стратеги төлөвлөлттэй уялдаж байдагтай холбоотойгоор тухайн салбарын жилийн хөрөнгө оруулалт, урсгал төсөвт зардал, хөрөнгө оруулалт суугаагүй бол дээрх асуудал шийдвэрлэгдэхгүй байгаа юм. Энэ нь олон талын хүндрэлийг тухайн салбарт үзүүлдэг бөгөөд жишээлбэл хилийн цэргийн хувьд автомашин техникийн парк шинэчлэлтийг үе шаттай тасалдуулалгүй хийхгүйгээс хилчид явгарах, мэдээлэл, холбооны техник хэрэгслийн шинэчлэл, сайжруулалт хийгээгүйгээс холбоогүй үүрэг гүйцэтгэх, инженерийн байгууламжийн засвар үйлчилгээний зардлыг өгөхгүйгээс улсын хил хамгаалах үйл ажиллагаагаа хэвийн явуулах

нөхцөл алдагдаж, улмаар хилчин, иргэний амь нас, эрүүл мэндтэй холбоотой эрсдэлүүд үүсэж, хилчдийг бодит аюулд оруулна. Цаашилбал улс орны аюулгүй байдалтай шууд хамааралтай болохыг шийдвэр гаргагчид харгалзан үзэхгүй байгаад харамсахаас аргагүй юм.

Үүний нэг жишээ нь саяхан болж өнгөрсөн "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль"-ийн хэлэлцүүлгийн үеэр 2019 онд эхэлсэн хилийн цэргийн парк шинэчлэлийг үргэлжлүүлэх боломжгүй болгож, төсвийн хөрөнгө оруулалтаас хассан явдал юм.

УИХ-ын гишүүн Ц.Сэргэлэн "УИХ-аас 2021 оны долдугаар сард батлагдсан Монгол Улсын хөгжлийн таван жилийн төлөвлөгөөнд багтсан, Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хилийн салбаруудын автомашинуудыг шийдэх асуудал ирэх оны төсөвт орсонгүй. Хилийн салбар гэдэг бол хилийн шугам дээр хоног тутам үйл ажиллагаа явуулж, улсын хилийн зөрчлийг хянан шалгах, таслан зогсоох үүрэгтэй. Хөрш орнуудтай хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн асуудлыг шийдвэрлэх, хилийн төлөөлөгч, орлогч нарын уулзалтын асуудал яг энэ хэсэгт л явагддаг. Одоо хилийн салбаруудын автомашины асуудал маш хүнд нөхцөлд

байгаа"¹ талаар төсвийн хэлэлцүүлгийн үеэр анхааруулж хэлсэн боловч хилийн цэргийн автопаркийн шинэчлэлийн 2022 онд үргэлжлүүлэх ажил дэмжигдээгүй юм.

Энэ мэт шалтгаан цаашид үргэлжилсээр байвал "Алсын хараа-2050" хөгжлийн бодлогод туссан "Дархан хил" хөтөлбөр хэрэгжихгүй байх магадлал өндөр байна.

Дүгнэлт, санал

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, салбарын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд "Дархан хил" Төр засаг, удирдлагаас дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх. Үүнд:

Монгол Улсын ҮАБЗ-ийн дэргэд "Цэрэг техникийн бодлогын хороо", төрийн цэргийн байгууллагуудын дэргэд "Цэрэг техникийн бодлогын салбар хороо" байгуулах;

Төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудад үндэсний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай цэрэг техникийн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны тасалдлыг арилгах зорилгоор цэрэг иргэний харилцаан дээр тулгуурласан цэрэг аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагаа

болон гадаад улсуудтай хийх цэрэг техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэн тэлж, улмаар цэрэг техникийн салбарт экспорт, импортын зохистой харьцааг хангах боломжийг бүрдүүлэх;

Хил хамгаалах байгууллага санаачлан, Монгол Улсын Их хурал дахь төлөөллийн дэмжлэгтэй "Цэрэг техникийн бодлого" баримт бичгийг боловсруулан, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаар батлуулж, хэрэгжүүлэх;

Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий батлан хамгаалах, хил хамгаалах, онцгой байдал, дотоодын цэрэг, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг тогтвортой байлгах эрх зүйн орчныг баталгаажуулах;

Монгол Улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах талаар бодлогын болоод эрх зүйн бусад шинэчлэлүүдийг үргэлжлүүлж, бодлого, хөтөлбөрийн судалгаа² 20 хийж, хэрэгжилтийг хангаж, эхлүүлэх; шуурхай, шинэчлэлийг зоримог

Албан ёсны бодлогын зэрэгцээ албан бус буюу зэрэгцээ

¹ Ц.Сэргэлэн. УИХ-ын чуулганы 2021.11.11-ны өдрийн хуралдааны тэмдэглэл

² А.Гэрэлмаа Бодлогын судалгааны арга зүй. 2 дах тал. Бодлогын судалгаа бол үйлчлүүлэгч буюу шийдвэр гаргагчид хандсан нөлөөллийн арга хэрэгсэл

бодлогын хувилбар боловсруулж, шийдвэр гаргагчдад санал болгох замаар тэдгээрийн зүгээс гаргах шийдвэрийн үндэслэлийг сайжруулахад туслах, нийтэд сурталчлах нь чухал гэж үзэж байна.

Эх сурвалж:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль. 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт. УБ.2020
2. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. 2014. УБ. 349 дэх тал
3. Рогозин. Д. Война и мир. Москва. 2014
4. Поповкин В.А. Первый заместитель Министра обороны РФ. Особенности военно-технической политики Российской Федерации в современных условиях. <http://federalbook.ru/files/OPK/Soderjanie/OPK-7/III/Popovkin.pdf>
5. https://www.sohu.com/a/465011225_635792
6. http://sipri.org/sites/default/files/2021-3/fs_2103.pdf
7. www.vesti.ru/Мировой рынок вооружений 2020: главные поставщики и покупатели увеличили активность
8. https://sipri.org/sites/default/files/2021-03/fs_2013_at_2020.pdf
9. https://www.sohu.com/a/465011225_635792
10. Монгол улсын дунд хугацааны (2020-2025) тогтвортой хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл (Тайлан III) 70 дах тал

11. Монгол улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоол. Монгол улсын батлан хамгаалах бодлогын үндэс, Нэг нийтлэл үндэслэл УБ
12. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. Нэг нийтлэл үндэслэл 1.1. УБ
13. Ш.Паламдорж. Монголын цэргийн шинэчлэл - ардчилсан иргэний хяналт. Женев-Улаанбаатар. 2003. 40 дэх тал
14. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. “Алсын хараа-2050 ” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого.
15. Ц.Сэргэлэн. УИХ-ын чуулганы 2021.11.11-ны өдрийн хуралдааны тэмдэглэл
16. А.Гэрэлмаа Бодлогын судалгааны арга зүй. 2 дах тал. Бодлогын судалгаа бол үйлчлүүлэгч буюу шийдвэр гаргагчид хандсан нөлөөллийн арга хэрэгсэл